

БАТЛАВ.  
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА




Ж.ЦОЛМОН

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ  
АЛБАНЫ АЖЛЫН БАЙРНЫ СУЛ ОРОН ТООНД НЭЭЛТТЭЙ  
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

Баримт бичгийн код	АХОЗШША - 25 - 45		
Баталсан огноо:	2025 он- 02 сар- 01 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр Ахиаах шилжинт шалсан	Огноо 2025.02.01	Гарын үсэг 
Боловсруулсан:	Албан тушаал, нэр Шилжинт шалсан	Огноо 2025.02.01	Гарын үсэг 

АЖЛЫН БАЙРНЫ СУЛ ОРОН ТООНД НЭЭЛТТЭЙ  
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1			Цэцэг ийн 2022	20250731	

Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1		
2		
3		

# АЖЛЫН БАЙРНЫ СУЛ ОРОН ТООНД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

## АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ АЖЛЫН БАЙРНЫ СУЛ ОРОН ТООНД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба (цаашид “Алба” гэх)-ны ажлын байранд мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэн, албаны үйл ажиллагааг олон улсын шаардлагад нийцүүлэн сайжруулахад оршино.

1.2. Албаны ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт явуулахад Монгол Улсын Хөдөлмөрийн тухай, Иргэний нисэхийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмыг баримтална.

1.4. Албаны ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт явуулахдаа хууль дээдлэх, ил тод, хараат бус байх, ашиг сонирхлоос ангид байх, шударга, эрх тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

### Хоёр. Ажлын байрны чиг үүрэг, ангилал

2.1. Албаны ажлын байрыг дараах чиг үүргийн хүрээгээр ангилна. Үүнд:

2.1.1. Захиргааны чиг үүрэг хэрэгжүүлэх ажлын байр;

2.1.2. Шинжлэн шалгагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх ажлын байр;

2.1.3. Туслах ажиллагааны чиг үүрэг хэрэгжүүлэх ажлын байр.

2.2. Ажлын байрны тодорхойлолтыг тухайн ажлын байрны чиг үүрэг, онцлог, түүнийг хэрэгжүүлэх ажилтанд тавих нийтлэг болон тусгай шаардлага (боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар), ажлын байрны нөхцөл зэргийг тусган батална.

### Гурав. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

3.1. Ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг дараах мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан нийтэд хүргэнэ:

3.1.1. Байгууллагын албан ёсны цахим хуудас: [www.aair.gov.mn](http://www.aair.gov.mn)

3.1.2. Хэвлэл мэдээллээр

**АЖЛЫН БАЙРНЫ СУЛ ОРОН ТООНД НЭЭЛТТЭЙ  
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ**

3.2. Сонгон шалгаруулалтыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- 3.2.1. Баримт материалыг хүлээн авах, бүрдүүлэх
- 3.2.2. Мэргэжлийн ур чадварыг шалгаж, ярилцлага хийх
- 3.2.3. Үнэлэх ажиллагаа, ажилд авах

3.3. Сонгон шалгаруулалтанд оролцогчоос дараах баримт материалыг бүрдүүлж авна:

- 3.3.1. албан хаагчийн анкет
- 3.3.2. боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг
- 3.3.3. албан тушаалд томилогдох хүсэлт
- 3.3.4. иргэний үнэмлэхийн хуулбар,
- 3.3.5. тухайн ажлын байрны чиг үүрэгтэй холбогдуулан мэргэшсэн байдал, ажлын туршлага болон бусад тусгай шаардлагыг нотлох баримт бичиг

3.4. Энэ журамын 3.3.-т заасан сонгон шалгаруулалтанд оролцогчоос ирүүлсэн баримт материалтай танилцаж, зарлагдсан ажлын байрны албан тушаалын тодорхойлолтын шалгуур хангагдаж байгаа эсэх, мэргэжлийн ур чадвар зэргийг харгалзан захиргааны асуудал эрхэлсэн мэргэжилтэн бичиг баримтын түвшинд сонгон шалгаруулж, шалгарсан анкетыг даргад танилцуулна.

3.5. Эхний шатанд тэнцсэн оролцогчийг дараагийн шатанд ярилцлагад урина.

3.6. Сонгон шалгаруулалтанд оролцогчийн мэргэжлийн ур чадвар, зан байдал, харилцаа, хандлагыг тодорхойлох зорилгоор ярилцлагыг албаны дарга, ахлах шинжлэн шалгагч болон захиргааны асуудал эрхэлсэн мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулна.

3.7. Ярилцлагаар мэргэжлийн ур чадварын шалгуурыг үндэслэн асуулт тавьж үнэлгээ өгнө.

3.8. Мэргэжлийн ур чадварыг шалгасан тухай ярилцлагын үр дүнг үндэслэн Албаны дарга шийдвэр гаргана.

Дөрөв: Сонгон шалгаруулалтын дараах ажиллагаа

4.1. Сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажилтны хувийн хэргийг бүрэн бүрдүүлж хүний нөөцөд хүлээн авна.

4.2. Ажилтныг ажилд томилсон тушаал гаргаж, хөдөлмөрийн гэрээ байгуулна.

4.3. Томилонгдсон ажилтанд “ажлын байран дээрх сургалт”-ыг зохион байгуулна

4.4. Сонгон шалгаруулалтанд тэнцээгүй оролцогчидод энэ тухай тайлбарыг мэдэгдэх ба ирүүлсэн материалыг буцаан өгнө.

----oOo----